



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/70

Улаан-Уул

Техникийн хяналтын үзлэг,  
тээврийн хэрэгслийн албан татвар  
хураалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/173 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь;

1.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн ажлыг 2022 оны 06 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд сумын төвд зохион байгуулсугай.

2.Тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийн ажлыг зохион байгуулах комиссыг хавсралтаар баталсугай.

3. 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 09:00 цагаас 06 дугаар сарын 11-ний өдрийн 21:00 цаг хүртэл олон нийтийн аюулгүй байдлыг хангаж архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож, архи, согтууруулах ундааг тоолж лацдахыг сумын цагдаа, цагдаагийн ахлагч (Г.Өнөболд), тээврийн хэрэгсэлийн стандарт шаардлагуудыг хангуулах, ашиглах боломжгүй тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг тооллогын комиссын дарга (Г.Баттогтох), татварын улсын байцаагч (Г.Эрдэнэсан), багуудын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


4.Үзлэгийн ажлыг зохион байгуулсан дүнгийн тухай илтгэх хуудсыг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн дотор ирүүлэхийг комиссын дарга (Г.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201125

Сумын Засаг даргын 2022 оны  
А/70 дугаар 06 сарын 24 ны өдрийн  
дүгээр захирамжийн хавсралт



ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ  
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР  
ХУРААЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ СУМЫН КОМИС

1. Комиссын дарга: Г.Баттогтох (Засаг даргын орлогч)
2. Гишүүд: Д.Эрдэнэчимэг (Улсын бүртгэгч)
3. Г.Эрдэнэсан (Татварын улсын байцаагч)
4. Г.Өнөболд (Сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч)
5. Ц.Доржбат (Олон нийтийн цагдаа)
6. Р.Пүрэв (Олон нийтийн цагдаа)
6. Багуудын Засаг дарга нар

----oOo----